

Дотоод хэргийн их сургуулийн
захирлын 2026 оны 06 дугаар сарын
18-ны өдрийн 4/366 дугаартай
тушаалын 2 дугаар хавсралт

“ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭТИЙН ЧИГ ХАНДЛАГА” 1119283239
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Зорилго: Цагдаагийн байгууллагын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, хөгжлийн чиг хандлагыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэлэлцэн тодорхойлох, олон улсын туршлага, инновац, дэвшилтэт технологид тулгуурласан онол, практикийн судалгааг нэгтгэн хэлэлцэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн орчин, хүний нөөц, менежмент болон иргэдэд чиглэсэн үйлчилгээний чанарыг боловсронгуй болгох арга замыг эрэлхийлэхэд оршино.

Зохион байгуулагч: Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургууль.

Зохион байгуулах газар: Танхим, цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Хугацаа: 2026 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр.

Хамрах хүрээ: Хууль зүйн салбарын мэргэжилтнүүд, хууль сахиулахуй аюулгүй байдлын салбарын судлаачид, практик байгууллагын ажилтан алба хаагч, олон улсын байгууллагын төлөөлөгчид, дотоодын болон гадаад улсын эрдэмтэн судлаачид, багш алба хаагчид.

Эрдэм шинжилгээний илтгэлийн ерөнхий чиглэл:

- Цагдаагийн байгууллагын хөгжлийн бодлого, стратеги, шинэчлэлийн чиг хандлага;
- Цагдаагийн байгууллагын дижитал шилжилт, хиймэл оюун ухааны хэрэглээ, ухаалаг хяналтын тогтолцоо;
- Кибер аюулгүй байдал, цахим гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагын чиг хандлага;
- Хүний эрхэд суурилсан цагдаагийн үйл ажиллагаа ба олон нийтийн оролцоо;
- Цагдаагийн байгууллагын хүний нөөц, манлайлал, ёс зүй, алба хаагчийн чадавх;
- Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, инновац;
- Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлын менежмент;
- Онцгой нөхцөл байдал, гамшиг, ослын үеийн цагдаагийн оролцоо, хамтын ажиллагаа;
- Цагдаагийн байгууллагын эрх зүйн орчин, шинэчлэл, ил тод байдал.

Илтгэлд тавигдах шаардлага:

1. Хэлбэрийн хувьд:

-Илтгэл нь сэдэв, илтгэгчийн овог, нэр, цахим хаяг, хураангуй, түлхүүр үг (англи хэл, монгол хэлээр), оршил, судалгааны ажлын үр дүн буюу үндсэн хэсэг, дүгнэлт, санал, хавсралт, ном зүйгээс бүрдэнэ.

2. Агуулгын хувьд:

-Их сургуулийн судалгаа, боловсруулалтын чиглэлд нийцсэн, чиглэлээр тодорхой тулгамдсан асуудлыг судлан авч үзэх;

-Тухайн асуудлыг онол, практикийн үүднээс судлан боловсруулж, тодорхой үр дүнд хүрсэн, түүнийгээ шинжлэх ухааны үүднээс үндэслэлтэй нотлох;

-Судалгааны шинэлэг тал, практик ач холбогдлыг тодорхойлох;

-Дэвшүүлсэн санал, дүгнэлт оновчтой, практикт нэвтрэх, хэрэгжих боломжтой байх;

3. Илтгэлд тавигдах техник шаардлага:

-Илтгэлийг Microsoft word программ дээр, бичгийн цаасны хэмжээ А4, Формат (дээд-2см, доод- 2см, зүүн-3см, баруун-1.5см)-аар, Мөр хоорондын зай 1.15, Arial үсгийн фонт, үсгийн өндөр 12pt, 8-12 талд багтаан туурвисан байна;

-Илтгэлийг хамтран бичиж болно;

-Ирүүлсэн илтгэлийг шүүн хэлэлцэж, хурлын эмхэтгэлд хэвлэнэ.

Илтгэл хүлээн авах хугацаа: Илтгэлийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 17 цаг хүртэл policeschool.uia@gmail.com цахим хаягаар хүлээн авна.

Холбоо барих утас: 99143073, 88820774, 89044035

Хурлын үр дүн: Илтгэлийн онол, практикийн ач холбогдлыг тодорхойлж, зөвлөмж боловсруулан, эрдэм шинжилгээ, судалгаа, практик үйл ажиллагааны эргэлтэд оруулж, эмхэтгэлийг цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.